



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 876

Улаанбаатар хот

┌ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ┐
ахуйн сарын аяныг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2025 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) сарыг жил бүрийн 4 дүгээр сард орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан ажил олгогч, ажилтнуудын ХАБЭА-н мэдлэгийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ХАБЭА-н сарын аяныг 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл дүүргийн хэмжээнд зарласугай.

2. Аяныг зарлагдсан хугацаанд чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, аяныг олон нийтэд суртчилан ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

3. Аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай

4. Зарцуулагдах 1,700,000 (нэг сая долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн
А/с... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХОТЫН СТАНДАРТ,
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ЗОХИОН БАЙГУУЛЖ
БАЙГАА "ЦЭВЭР АЮУЛГҮЙ ХУДАГ" АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026.04.06

Багахангай дүүрэг

№	Хэрэгжүүлэх арга хэмсжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
1	Төлөвлөгөө боловсруулж, батлуулах	2026.04.01- 2026.04.06	ЗДТГ-ын ХСТНААХэлтэс
2	Аяны удирдамж боловсруулж, батлуулах	2026.04.01- 2025.04.06	ЗДТГ-ын ХСТНААХэлтэс
3	Дүүрэгт ХАБЭА-н аяны хүрээнд зохион байгуулах тэмцээний удирдамж боловсруулж, батлуулах	2026.04.01- 2026.04.06	ЗДТГ-ын ХСТНААХэлтэс Багахангай УСАТ
4	Аяны явцад хяналт шалгалтыг зохион байгуулах	2026.04.15 2026.04.30	ЗДТГ-ын ХСТНААХэлтэс
5	Аж ахуй нэгж байгууллага аяны тайлан мэдээг фото зургаар баримтжуулан ХСТНААХ-т хүргүүлэх	2026.05.04	ААНБ
6	Цэвэр худаг аяны тайланг нэгтгэн танилцуулах	2026.05.08	ЗДТГ-ын ХСТНААХэлтэс

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн
04 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ДЭД БҮТЦИЙН 3 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1	Заал түрээс (1 өдөр)	1	160	160,000
2	Шүүгч, зохион байгуулагч	1 хүн	100	100,000
Дүн				260,000
Шагнал				
1	Цом	1	120,000	120,000
2	Волейбол	1 байр	200,000	200,000
3		2 байр	180,000	180,000
4		3 байр	160,000	160,000
5	Дартс	1 байр	120,000	120,000
6		2 байр	100,000	100,000
7		3 байр	80,000	80,000
8	Корнохол	1 байр	120,000	120,000
9		2 байр	100,000	100,000
10		3 байр	80,000	80,000
11	Өргөмжлөл жаазтай	9	20,000	180,000
Нийт дүн				1,700,000